

ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ  
ᠠᠤᠳᠢᠲᠤ ᠬᠠᠵᠠᠷ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
2024 ОНЫ НЭГДСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2025/001/НА-СТА-ТЕЗ

Тайлан бэлтгэсэн:

Сүхбаатар аймгийн  
Төрийн аудитын  
газрын дарга,  
тэргүүлэх аудитор:  
Г.Даваа

Аудитын менежер:  
М.Нарантуяа

Ахлах аудитор:  
Ө.Золзаяа

Аудитор:  
Б.Мөнхбамбар

2025 оны 4 дүгээр  
сар

Уг тайланг УАГ-ын  
Цахим хуудаснаас  
үзнэ үү.  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Хаяг: Нутгийн  
удирдлагын 2 дугаар  
байр, Балдан-  
Осорын гудамж, 7  
дугаар баг, Баруун-  
Урт сум, Сүхбаатар  
аймаг

## Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	2
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ .....	2
1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ...	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.	9
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.АУДИТЫН ТАЙЛАН .....	11
3.1 Байгууллагын талаарх мэдээлэл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй 12	
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт .....	13
3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	13
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	14
4.2 Авлага .....	16
4.3 Бараа материал.....	19
4.4 Урьдчилгаа.....	20
4.5 Үндсэн хөрөнгө.....	21
4.6 Өр төлбөр.....	23
4.7 Засгийн газрын хувь оролцоо .....	24
4.8 Орлогын данс .....	25
4.9 Зардал .....	26
4.10 Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил, залруулга .....	28
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	33
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	33
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ .....	33

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БОГ	Байгаль орчны газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮТП	Үйлдвэр технологийн парк
ХХК	Хувьцаат хязгаарлагдмал компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт №2	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл данс бүрээр
Хүснэгт №3	Авлагын үлдэгдэл
Хүснэгт №4	Хоршоо хөгжүүлэх сангийн авлага
Хүснэгт №5	Бараа материалын үлдэгдэл
Хүснэгт №6	Улсын нөөцөөс олгосон бараа жагсаалт
Хүснэгт №7	Урьдчилгаа дансны үлдэгдэл
Хүснэгт № 8	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт № 9	Нийт өр төлбөрийн үлдэгдэл
Хүснэгт № 10	Засгийн газрын оролцоо
Хүснэгт №11	Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт№12	Зардлын бүртгэл
Хүснэгт№13	Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байгууллага
Хүснэгт№14	Төсвийн шууд захирагчийн зөрчлийн судалгаа
Хүснэгт№15	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн судалгаа
Хүснэгт№16	ОНӨААТҮГ-ын зөрчлийн судалгаа
Хүснэгт № 17	Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт
Хүснэгт № 18	Дулаан зогсоол, автомашины гражийн судалгаа

# 1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.04.25 № 395  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА М.ИДЭРБАТ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа зөрчил, түүний санхүүгийн тайлан, тодруулгад үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс хэмжиж, толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотойгоор нийт 957.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд энэ нь шагнал, урамшууллаас ХХОАТ суутгаагүй, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу ажил гүйлгээ хийсэн, мөн төсөв захирагч, нягтлан бодогч, нярав болон хамаарал бүхий этгээдийн хувийн харилцах дансаар дамжуулан төсвийн хөрөнгийг зарцуулсан,

2. Бараа материалын данстай холбоотой нийт 1,267.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд хөрөнгийг бүртгэлд тусгалгүй зарцуулсан, шаардлагагүйгээр их хэмжээгээр материал нөөцөлсөн, анхан шатны баримтгүйгээр зарлагдсан, хандив тусламжаар ирсэн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй,

зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан нөөцийн өвсийг данс бүртгэлд тусгаагүй,

3.Төсвийн зарцуулалттай холбоотой нийт 254.0 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгох, түр орлон гүйцэтгэж буй албан хаагчдад цалингийн зөрүү олгох, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгох зэрэг нь төсвийн зориулалтыг зөрчиж, зохих журмаар баталгаажуулаагүй зардлууд гарсан. Мөн албан томилолтын зардал хэтрүүлэн зарцуулсан, хоолны хөнгөлөлт, суудлын мөнгө, мөн зориулалтгүй болон үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй зарцуулалт хийсэн,

4.Авлагын данстай холбоотой нийт 201.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс сум хөгжүүлэх сангаас зээлд хамрагдсан зарим иргэд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, зээлийг хугацаа хэтрүүлсэн асуудлыг шүүхийн байгууллагад шилжүүлж анхан шатны шүүхийн шийдвэр болон эвлэрүүлэн зуучлахаар гэрээ байгуулсан боловч зээл, зээлийн хүүг өнөөг хүртэл төлөөгүй байна.

Эдгээр бүртгэлийн болон хууль тогтоомжийн нийцэл хангаагүй алдаа, зөрчлүүд нь шинж чанарын болоод тоон дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй бөгөөд санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “тохиолдсон байх”, “үнэлгээ ба хуваарилалт”, “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Зудын нөхцөл байдалтай холбоотойгоор Сүхбаатар аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бараа материалын дансанд малын зүй бус хорогдол болон нөөцийн өвс, тэжээлийн зарцуулалттай холбоотой нийт 1,031.3 сая төгрөгийн гүйлгээ мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлсэн бөгөөд энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, ил тод байдлыг хангах шаардлагатай нөхцөл үүсгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад нийт 3,360.7 сая төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн бөгөөд эдгээр нь нягтлан бодох бүртгэлийн (НББ) бодлого, дотоод хяналт, удирдлагын тогтолцооны сул байдлаас үүдэлтэй байна.

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, орлогын данс зэрэгт илэрсэн алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, ил тод байдалд сөргөөр нөлөөлж, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт бүрэн тодорхойлоогүй, зарим төсөл арга хэмжээнд үр дүнгийн нотолгоо

бүрдээгүйгээс хөгжлийн зорилтот түвшин, бодит гүйцэтгэлийн хооронд зөрүүтэй үнэлгээ хийгдэж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөө бүдгэрч, төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чанарт сөргөөр нөлөөлөл бий болгож байна.

Хөрөнгө оруулалтын 413 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэл 46 хувьтай байгаа нь зураг төсөвгүй, тендер зарлаагүй, хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй, худалдан авах ажиллагааны удаашрал зэрэг шалтгаантай бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтын үр ашиг, төрийн үйлчилгээний хүртээмжийг бууруулж байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		49,816,470.3	59,745,716.6
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	24,731,428.1	31,469,365.1
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	4,939,872.1	4,110,676.6
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	35,289.5	154,711.5
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	3,482,021.1	3,738,632.0
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	83,833.6	108,511.8
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	16,544,025.9	20,163,819.6
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		73,051,893.1	75,354,204.3
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	73,051,893.1	75,354,204.3
39200	<b>Биет хөрөнгө</b>		64,191,091.2	66,386,860.0
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	13	8,852,106.9	8,938,594.4
39400	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	14	8,695.0	28,750.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		122,868,363.4	135,099,920.9
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		36,147,211.2	36,228,767.3
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	23,332,671.4	23,646,967.5
41200	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	16а, 16б	663,250.9	642,162.1
41300	<b>Өглөг</b>	17а, 17б	1,668,401.4	1,394,660.5
41400	<b>Урьдчилж орсон орлого</b>	18а, 18б	21,001,019.1	21,610,145.0
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		12,814,539.8	12,581,799.8
42200	<b>Урт хугацаат зээл</b>	20а, 20б	12,814,539.8	12,581,799.8
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		86,721,152.2	98,871,153.6
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		86,721,152.2	98,871,153.6
51100	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>		34,606,863.2	34,647,339.2
51101	<b>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</b>		2,955,971.6	4,945,071.6
51106	<b>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</b>		236,956.0	236,956.0
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		38,848,461.9	48,968,887.3
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>		10,072,899.6	10,072,899.6
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		122,868,363.4	135,099,920.9

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		189,545,080.30	102,043,764.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО		32,764,179.20	37,576,804.10
110	Орлогын албан татвар		27,110,791.00	29,830,480.80
1100	Хувь хүний орлогын албан татвар		12,300,245.60	21,007,415.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-581,981.30	-761,159.00
1103	ААН-ын орлогын албан татвар		15,392,526.70	9,584,223.90
113	Хөрөнгийн албан татвар		2,290,998.00	2,480,364.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж		3,362,390.30	5,265,958.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	53,631,210.20	61,756,594.60
120	Нийтлэг татварын бус орлого		26,756,182.60	30,217,888.40
121	Хөрөнгийн орлого		114,986.60	102,088.20
122	Тусламжийн орлого		0	3,620.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		26,760,041.00	31,432,998.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		103,149,690.90	2,710,365.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	157,348,295.80	70,013,981.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ		156,437,308.10	69,978,260.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		84,231,316.40	66,058,195.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		11,625,006.80	17,561,783.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,417,366.60	2,136,307.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		898,226.90	9,023,693.10
2104	Хангамж, бараа материалын зардал		30,621,991.20	1,576,028.20
2105	Нормативт зардал		12,617.70	18,145.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		512,861.70	1,572,654.20
2107	Томилолт, зочны зардал		346,277.90	467,898.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,614,852.40	14,969,944.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		21,182,115.10	18,731,739.60
212	ТАТААС		868,936.30	1,429,232.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		71,337,055.40	2,490,832.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		910,987.60	35,721.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		32,196,784.60	32,029,782.60
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0	29,318.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		23,358,550.80	19,989,325.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		8,838,233.80	12,069,775.20

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	69,445,560.5	69,445,560.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,648,928.6	4,648,928.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,094,489.1	74,094,489.1

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-852.2	-852.2
7	Өмчид гарсан өөрчилөлт	3,789,281.6	3,789,281.6
9	Тайлант үеийн үр дүн	8,838,233.8	8,838,233.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,721,152.2	86,721,152.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	86,721,152.2	86,721,152.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	39,750.2	39,750.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,760,902.4	86,760,902.4
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	35,122.0	35,122.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	5,354.0	5,354.0
19	Тайлант үеийн үр дүн	12,069,775.2	12,069,775.2
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	98,871,153.6	98,871,153.6

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	118,509,579.6	104,605,176.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	32,729,861.2	37,579,108.9
110	Орлогын албан татвар	27,076,473.0	29,857,935.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	12,265,927.6	21,009,945.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-581,981.3	-761,159.0
1103	ААН-ын орлогын албан татвар	15,392,526.7	9,584,223.9
113	Хөрөнгийн албан татвар	2,290,998.0	2,480,364.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,362,390.3	5,265,733.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	336,963.7	649,759.8
1181	Газрын төлбөр	1,520,991.1	2,657,668.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,445,932.9	1,958,305.2
1183	Бусад татвар	58,502.7	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,124,947.7	64,247,308.1
120	Нийтлэг татварын бус орлого	27,261,030.1	32,712,221.8
121	Хөрөнгийн орлого	103,876.6	102,088.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	26,760,041.0	31,432,998.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,654,770.7	2,778,759.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,820,608.0	74,648,619.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,820,608.0	74,648,619.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,871,378.3	70,700,337.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,561,757.6	24,286,110.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,824,669.2	4,052,944.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,214,763.4	10,365,583.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,783,600.3	6,965,514.2
2105	Нормативт зардал	12,171.3	31,909.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	518,010.8	1,616,438.0
2107	Томилолт, зочны зардал	341,033.1	453,955.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,782,178.8	9,955,605.6

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,833,193.9	12,972,276.1
212	ТАТААС	70,000.0	1,446,992.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	879,229.7	2,501,289.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	59,688,971.7	29,956,557.6
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	9,588.9	12,084.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	48,341,459.9	22,706,564.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,341,459.9	22,706,564.8
2200	Дотоод эх үүсвэрээр	48,341,459.9	22,706,564.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-48,331,871.0	-22,694,480.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,442,669.4	-524,140.1
14	Бусад эх үүсвэр	47,291.8	1,576.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,439,736.9	500,355.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	50,224.4	25,360.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	9,914,431.3	6,737,937.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,816,996.8	24,731,428.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,731,428.1	31,469,365.1

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТГ тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,951,496.8	72,862,755.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,993,020.8	52,384,310.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,853,231.7	48,512,131.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,806,275.2	16,749,336.8
210101	Үндсэн цалин	8,936,437.0	8,468,466.2
210102	Нэмэгдэл	6,612,881.3	6,213,814.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	868,814.7	782,841.3
210104	Урамшуулал	861,375.2	794,008.7
210105	Гэрээт ажлын хөлс	526,767.0	490,205.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,226,860.9	2,040,030.9
210201	Тэтгэврийн даатгал	1,508,476.4	1,406,791.0
210202	Тэтгэмжийн даатгал	173,529.4	158,602.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	140,638.4	105,337.5
210204	Ажилгүйдлийн даатгал	48,901.2	54,232.4
210205	Эрүүл мэндийн даатгал	355,315.5	315,067.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,437,096.3	8,858,467.6
210301	Гэрэл, цахилгаан	1,086,899.8	1,007,692.8
210302	Түлш, халаалт	7,403,918.8	7,017,766.3
210303	Цэвэр, бохир ус	871,877.7	756,719.6
210304	Байрны түрээс	74,400.0	76,288.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,006,078.7	942,663.4
210401	Бичиг хэрэг	158,897.1	155,142.0
210402	Тээвэр, шатахуун	606,029.4	591,568.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,494.4	76,355.3
210404	Ном, хэвлэл	8,220.0	4,297.5

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,658.3	18,612.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	111,779.5	96,687.8
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,550.0</b>	<b>18,002.8</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,550.0	18,002.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,239,460.7</b>	<b>2,078,501.2</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	611,515.5	605,551.6
210602	Тавилга	182,359.3	163,925.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,549.7	9,379.9
210604	Урсгал засвар	1,434,036.2	1,299,643.8
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>453,690.2</b>	<b>427,319.1</b>
210701	Гадаад албан томилолт	10,000.0	9,962.2
210702	Дотоод албан томилолт	443,690.2	417,356.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,549,193.1</b>	<b>6,010,428.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,454,979.4	5,935,556.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,500.0	2,566.0
210803	Даатгалын үйлчилгээ	22,391.2	19,131.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,263.2	5,914.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,904.5	1,680.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,625.0	35,679.4
210807	Газрын төлбөр	12,129.8	8,700.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000.0	300.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,400.0	899.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,116,026.6</b>	<b>11,387,381.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,853,679.8	11,147,557.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	262,346.8	239,824.5
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>1,453,552.8</b>	<b>1,446,992.8</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>712,568.5</b>	<b>712,568.5</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	712,568.5	712,568.5
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>740,984.3</b>	<b>734,424.3</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	740,984.3	734,424.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,686,236.3</b>	<b>2,425,186.1</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,686,236.3</b>	<b>2,425,186.1</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	278,631.8	276,675.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	994,365.0	341,906.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,000.0	42,998.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	312,271.0	224,707.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,632,763.7	1,151,220.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	423,204.8	387,678.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>41,238,274.9</b>	<b>19,978,089.0</b>
220001	Барилга байгууламж	9,479,907.4	4,967,002.6
221001	Их засвар	5,630,246.8	3,635,322.5
222001	Тоног төхөөрөмж	2,660,652.9	1,294,830.5
223001	Бусад хөрөнгө	23,467,467.8	10,080,933.4
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>2,720,201.1</b>	<b>500,355.8</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	2,720,201.1	500,355.8
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>103,951,496.8</b>	<b>76,574,839.2</b>

<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>18,215,728.9</b>	<b>17,515,409.0</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	18,215,728.9	17,515,409.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>75,111,533.1</b>	<b>55,216,289.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	75,111,533.1	55,216,289.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>10,624,234.8</b>	<b>3,843,141.1</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,046,803.6	832,079.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,258,142.8	3,011,061.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,319,288.4	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	5,993,508.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	9,705,592.2

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,054,081.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,025,038.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,121,676.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,460.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,549.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,585.8
2104	Хангамж, бараа материалын зардал	233,532.2
2105	Нормативт зардал	10,489.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,208.8
2107	Томилолт, зочны зардал	20,824.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	723,609.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,996,417.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>903,361.3</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	467,703.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	435,657.9
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,043.8</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	29,043.8
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,028,499.9</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,028,499.9
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	497,071.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,163,732.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	717,840.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,649,855.3

## 3.АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Байгууллагын талаарх мэдээлэл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг танилцуулж байна.

Аудитын үйл ажиллагаа нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоонд хийсэн үнэлгээнд үндэслэн гүйцэтгэсэн бөгөөд аудитын явцад илэрсэн зөрчил, алдаа, анхаарал хандуулах шаардлагатай асуудлууд, тэдгээрт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдэл, аудитын санал дүгнэлтийн агуулга, үндэслэлийг хураангуйлан тусгав.

Төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, ашиглалт, хадгалалтад хяналт тавих чиглэлээр өгсөн зөвлөмж, саналуудыг “Менежментийн захидал”-д багтаан хүргүүлсэн болно.

Аудитын шалгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 05-наас 20-ны өдрүүдэд зохион байгуулж, аудитын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулсан бөгөөд уг тайланг Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 02/310 тоот албан бичгээр ирүүлснийг үндэслэн боловсруулав.

Тус аудитын үйл ажиллагааг ахлах аудитор Ө.Золзаяа, аудитор Б.Мөнхбамбар нар гүйцэтгэв.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Сүхбаатар аймгийн Засаг дарга нь “Мэдлэгт суурилсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тээвэр логистикийн хөгжлийн тулгуур төв болох” эрхэм зорилго дэвшүүлж, аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг 13 зорилт 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг хангасан байна.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 сарын 20-ны өдрийн 08 тогтоолоор аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хэлэлцэж нийт төлөөлөгчдийн 100 хувийн саналаар "Хангалттай" гэж үнэлжээ.

Аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос хуулийн 19 дугаар зүйлийн 19.5, 19.6.3, 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтууд хамааралтай байна.
- УИХ-ын 2023 оны 06 сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг шинэчлэн найруулга хийгдэж, 2024 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн байна.
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2 удаа өөрчлөлт оруулснаас Засаг даргын чиг үүрэгтэй холбоотойгоор тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.2, 60 дугаар зүйлийн 60.2, ЗДТГ-ын бүтэц орон тоотой холбоотой 67 дугаар зүйлийн 67.2-т дахь заалтууд өөрчлөгдсөн.
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2 удаа нэмэлт өөрчлөлт орсноос 6 дугаар зүйлийн 6.5.21, 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7-т Засаг даргын чиг үүрэгтэй холбоотой заалт өөрчлөгдсөн байна.
- Хөдөлмөрийн тухай тухай хуульд 2 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд 145 дугаар зүйлийн 145.4 дэх заалт төсвийн байгууллагуудад хамааралтай байна.

- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд тусгаснаар улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 11,939.2 сая төгрөгөөр баталсан бол 2024 оны 08 сарын 30-ны өдрийн хуулиар 13,917.6 сая төгрөг болгон нэмэгдүүлжээ.

Мөн Засгийн газрын тогтоол, салбарын сайдын баталсан журам зааврын шинэчлэл, өөрчлөлтийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2009 онд боловсруулагдсан бөгөөд сүүлийн жилүүдэд Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), холбогдох хууль, журам, зааварт гарсан өөрчлөлт шинэчлэлтийг тусган шинэчилж батлаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлээгүй нь бүртгэл хөтлөлт, санхүүгийн мэдээллийн ил тод байдал, үнэн зөв байдлыг хангах нөхцөлд сөргөөр нөлөөлж, санхүүгийн тайланг буруу илэрхийлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын баталсан журам, зааврыг мөрдөхгүй байх, түүнчлэн аудитын үнэлгээ, дүгнэлтэд эрсдэл үүсэх зэрэг үр дагавар дагуулах нөхцөл бүрдүүлж байна.

Иймд нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг холбогдох хууль, олон улсын стандартын шинэчлэлтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө төлөвлөлтөөс зөрүүгүй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын харьяа төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-ын нийт 29 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, 75 объектын үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар нийт 1,001.9 сая төгрөгийн зөрчил илрүүлжээ. Илэрсэн алдаа, зөрчлийн 19 хувь буюу 190.1 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, 81 хувь буюу 811.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж шийдвэрлэснээс төлбөрийн акт 4.2 хувь, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь буюу бүрэн биелсэн байна.

### **3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Сүхбаатар аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт

зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг аймгийн Засаг даргын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 85,037.3 сая төгрөгийн 1.5 хувь буюу 1,275.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь болох 956.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

##### **4.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Тайлант оны мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 24,731.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 31,469.3 сая төгрөг болж өмнөхөөс 6,737.9 сая төгрөг буюу 27.2 хувиар өсжээ.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.9	1.0	0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	24,730.5	31,468.3	6,737.8
<b>Дүн</b>	<b>24,731.4</b>	<b>31,469.3</b>	<b>6,737.9</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	5,993.5	9,705.6	3,712.1
Төсөл/ сан	6,185.3	8,747.1	2,561.8
Төрийн сан	11,092.7	12,374.8	1,282.1
ОНӨҮГ	1,459.9	641.8	(818.1)
<b>Дүн</b>	<b>24,731.4</b>	<b>31,469.3</b>	<b>6,737.9</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгө дансны нийт эцсийн үлдэгдлийн 9,705.6 сая төгрөг буюу 30.8 хувийг төсөвт байгууллага, 8,747.1 сая төгрөг буюу 27.8 хувийг төсөл сан, 641.8 сая төгрөг буюу 2 хувийг орон нутгийн өмчит байгууллага, 12,374.8 сая төгрөг буюу 39.3 хувийг төрийн сангийн үлдэгдэл тус тус эзэлж байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг сум болон данс тус бүрээр харуулбал:

*Хүснэгт №2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл данс бүрээр /сая төгрөг/*

Сумын нэр	Ерөнхий данс	ОНХСан	Сум хөгжүүлэх	Нэмэлт санхүүжилт	Боловсрол, ЭМСан	Хөрөнгө оруулалтын барьцаа	Техник хяналтын зардал	Авто замын сан
Асгат	234.9	282.3	8.3	2.6	-	-	-	-
Баяндэлгэр	348.1	860.4	128.9	11.7	-	-	-	-
Дарьганга	181.8	444.3	56.9	-	-	-	-	-
Мөнххаан	379.7	501.7	102.4	7.6	-	-	-	-
Наран	459.3	223.7	132.7	-	-	-	-	-

Онгон	822.2	725.6	152.1	29.7	-	-	-	-
Сүхбаатар	57.5	775.2	39.1	17.8	163.6	-	-	-
Түвшинширээ	345.6	605.7	207.6	3.3	-	-	-	-
Түмэнцогт	277.4	330.0	220.3	1.0	-	-	-	-
Уулбаян	128.0	102.5	142.9	4.3	-	-	-	-
Халзан	507.1	641.8	59.5	5.7	-	-	-	-
Эрдэнэцагаан	1,067.5	498.9	171.8	118.2	-	-	-	-
Баруун-Урт	4,111.1	845.5	442.5	8.2	-	-	-	-
Аймаг	2,970.0	11.3	-	274.5	-	8,747.1	187.6	640.5
<b>Нийт</b>	<b>11,890.2</b>	<b>6,848.9</b>	<b>1,865.0</b>	<b>484.6</b>	<b>163.6</b>	<b>8,747.1</b>	<b>187.6</b>	<b>640.5</b>

Төрийн сан дансны нийт үлдэгдлийн 12,374.8 сая төгрөгийн 11,890.2 сая төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл, 484.6 сая төгрөг нэмэлт дансны үлдэгдэл байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах хөрөнгийн үлдэгдэл байна.

- **Ерөнхий орлогын данс:** Ерөнхий орлогын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,177.8 сая төгрөгөөр өсөж 11,890.2 сая төгрөг болжээ. Үүнд Баяндэлгэр, Мөнххаан, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Халзан, Дарьганга, Баруун-Урт сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл гол нөлөөллийг үзүүлсэн ба энэ нь зарим нэр төрлийн орлого давж биелсэн, төлөвлөгдөөгүй орлого төвлөрөх зэрэг нийтлэг шалтгаантай байна. Тухайлбал: Тайлант онд Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн, Эрдэнэс таван толгой ХК-аас иргэн бүрд ногдол ашиг олгосон, орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй компаниудын тээврийн хэрэгсэлд аймгийн дугаар олгосон, арилжааны банк болон ББСБ дахь иргэдийн хадгаламж өссөн, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тусгай зөвшөөрлийн хураамж нэмэгдсэн нь татварын орлого давж биелэхэд нөлөөлсөн байна. Мөн Баяндэлгэр, Наран, Түмэнцогт, Халзан, Эрдэнэцагаан сумдад идлэг шонхор шувуу ашигласны төлбөр 414.1 сая төгрөгийн орлого төвлөрснийг үлдэгдлээр илэрхийлсэн. Эрдэнэцагаан сум байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 135.6 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлогыг төвлөрүүлсэн байна. Идлэг шонхор шувууны жишиг үнэ, төлбөр хураамж, гадаадад жил бүр гаргах тоо хэмжээний хязгаарыг МУ-ын Засгийн газраас тогтоодог ба тухайн орлогыг бодитой төлөвлөх, биелэлтийг тооцоход гадаад хүчин зүйлээс шалтгаалан хүндрэлтэй байдаг.
- **Орон нутгийн хөгжлийн сан:** Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,848.9 сая төгрөг болж өмнөх оноос 3,151.1 сая төгрөг буюу 85 хувиар өссөн байна. Энэ нь төсөл арга хэмжээ нь холбогдох баримт бичиг дутуугаас худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тендер зарласан боловч амжилтгүй болсон, бүрэн хэрэгжээгүй, техникийн тодорхойлолтод заасан шалгуур, нөхцөлд нийцээгүй, гэрээг дүгнэж, улсын комисс хүлээж аваагүй нь ОНХС-ийн дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.
- **Хоршоо хөгжүүлэн сан:** Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас Асгат сум 45.0 сая, Дарьганга сум 70.0 сая, Баруун-Урт сум 40.0 сая нийт 155.0 сая төгрөгийн зээлийг олгосон ба ХХС-ийн зээлд хамрагдахаар ирүүлсэн төсөл, арга хэмжээ тухайн журмын шаардлагад нийцээгүйгээс гүйцэтгэл хангалтгүй байсан нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.
- **Хөрөнгө оруулалтын барьцаа:** Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8<sup>1</sup> дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн

<sup>1</sup> Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42.6-д заасны дагуу зохицуулна.

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний үлдэгдлийг 8,747.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

- **Авто замын сан:** Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйгээс 640.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө үлдсэн байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 957.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 95.7 сая төгрөгийн алдааг залруулж, 30.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 786.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 45.3 сая төгрөгийн зөвлөмж хүргүүллээ. Үүнд: Зөрчлийг байгууллагаар ангилж харуулбал:

- *Шагнал, урамшууллаас 36.5 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй. /Сүхбаатар аймгийн ЗДТГ, Дарьганга, Онгон, Сүхбаатар сумдын ЗДТГ, Асгат сумын ИТХ/*
- *Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу 59.5 сая төгрөгийн ажил гүйлгээ гаргасан. /Түвшинширээ, Наран сумдын ЗДТГ, Халзан сумын ИТХ, Сүхбаатар аймгийн Байгаль орчны газар/*
- *Байгууллагын төсөв захирагч, нягтлан бодогч, нярав, хамаарал бүхий этгээдийн хувийн харилцах дансаар дамжуулан 208.5 сая төгрөгийн зарцуулалт гаргаж, санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг алдагдуулах эрсдэл үүссэн. /Дарьганга, Түвшинширээ сумын ЗДТГ, Уртын гэгээ ОНӨААТҮГ/*
- *Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 557.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Асгат, Дарьганга, Наран сумын ОНХС, Дарьганга, Наран сумын ЗДТГ, Уртын гэгээ ОНӨААТҮГ/*
- *Дотоод хяналт, санхүүгийн сахилга бат, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалттай холбоотой зөрчилтэй болон өмнөх оны аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүллээ. /Баяндэлгэр сумын ЗДТГ, Уртын гэрээ, Хайлааст голомт ОНӨААТҮГ/*

**Тайлант онд илэрсэн зөрчлүүд нь төсвийн сахилга хариуцлага, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж, санхүүгийн удирдлага, хяналтын тогтолцоонд системийн түвшний доголдол байгааг харуулж байна. Шагнал, урамшууллаас хуульд заасан ёсоор татвар суутгал хийгээгүй, анхан шатны баримтын иж бүрдлийг хангалгүй гүйлгээ бүртгэсэн нь санхүүгийн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулж байна.**

**Мөн байгууллагын төсвийн хөрөнгийг албан ёсны дансны бус, хувийн харилцах дансаар дамжуулан зарцуулсан нь ил тод байдал, хяналт, хариуцлагын үндсийг зөрчсөн үйлдэл болж байна. Үүнээс гадна, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулах нөхцөлийг алдагдуулсан байна. Түүнчлэн өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, хариуцлага тооцоогүй байдал нь зөрчил давтагдах, удирдлагын хяналтын үр нөлөө буурч байгааг харуулж байна.**

## **4.2 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 4,939.9 сая төгрөг байсан бол тайлант оны эцэст 4,110.7 сая төгрөг болж, нийтдээ 829.2 сая төгрөгөөр буюу 16.8 хувиар буурсан байна. Нийт авлагын бууралтад сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 523.1 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн. Энэ нь тус сангаас хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүйтэй холбоотой бөгөөд зээл хүссэн төсөл, арга хэмжээнүүд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 5, 6.3, 6.4 дэх заалтад заасан шалгуур үзүүлэлтүүдийг


хангаагүй тул сонгон шалгаруулалт зохион байгуулагдаагүй болно.

<i>Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл</i>		<i>/ сая төгрөг/</i>	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.1	2.6	0.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	347.0	286.0	(61.0)
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.4	0.4
Зээлийн хүүгийн авлага	49.3	36.9	(12.3)
Дансны авлага /ТӨҮГ/	1,049.0	1,048.9	(0.1)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	19.5	20.8	1.3
Бусад авлага	3,113.8	2,605.4	(508.3)
Зээлийн авлага	359.2	109.6	(249.6)
<b>Дүн</b>	<b>4,939.9</b>	<b>4,110.7</b>	<b>(829.2)</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,588.7	2,748.6	(840.1)
Төрийн сан	174.7	210.3	35.5
ОНӨҮГ	1,176.4	1,151.8	(24.6)
<b>Дүн</b>	<b>4,939.9</b>	<b>4,110.7</b>	<b>(829.2)</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 67 хувь буюу 2,748.6 сая төгрөг төсөвт байгууллага, 28 хувь буюу 1,151.8 сая төгрөг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 5 хувь буюу 210.3 сая төгрөг төрийн сангийн авлага эзэлж байна.

Авлагын насжилтын бүтэц (сая төгрөгөөр)



Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2024 оны санхүүгийн тайлангийн дүнгээс үзвэл, нийт 1,151.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс 6-9 жилийн насжилттай авлага 29.3 хувь буюу 337.7 сая, 10-аас дээш жилийн хугацаатай авлага 18.1 хувь буюу 208.5 сая төгрөг байна. Тухайлбал, “Дөрвөлж” ОНӨААТҮГ 208.5 сая, “Сүхбаатар хөгжил ҮТП” 319.3 сая, “Хайлааст голомт” 14.5 сая, “НьюДарьганга” 3.5 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагатай байна.

Эдгээр авлагын хугацаа хэтэрсэн байдал нь найдваргүй авлагын хэмжээ өсөх, хөөн хэлэлцэх хугацаа дуусах, шүүхийн маргаан үүсэх зэрэг хууль эрх зүйн эрсдэл бий болгохын зэрэгцээ

байгууллагуудын санхүүгийн болон үйл ажиллагааны тогтвортой байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд дээрх авлагыг ангилж, үнэлгээ хийх, шаардлагатай бол хууль зүйн дагуу арга хэмжээ авч, бүртгэлээс хасах, эргэн төлөлтийг эрчимжүүлэх зэрэг шийдвэртэй арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Авлага данс нийт дүнгээр өмнөх оноос буурсан боловч Асгат сум 32.5 сая төгрөг, Баяндэлгэр сум 6.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Авлагын дансны үлдэгдлийг сумдаар харуулбал:

*Хүснэгт №4 Авлагын үлдэгдэл сумдаар*

*/сая төгрөг/*

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
------------------	-------------------	--------------------	--------------------------

Сүхбаатар шууд	1,512.2	1,495.4	-16.8
Асгат сум	182.5	215.0	32.5
Баяндэлгэр сум	197.6	204.4	6.8
Дарьганга сум	228.2	211.6	-16.6
Мөнххаан сум	219.3	164.4	-54.9
Наран сум	128.3	104.8	-23.5
Онгон сум	239.8	118.0	-121.8
Түвшинширээ сум	119.2	75.0	-44.2
Түмэнцогт сум	96.3	59.3	-37.0
Уулбаян сум	102.8	64.8	-38.0
Халзан сум	211.8	180.4	-31.4
Эрдэнэцагаан сум	500.8	234.8	-266.0
Баруун-Урт сум	878.0	680.5	-197.4
Сүхбаатар сум	323.3	302.4	-20.9
<b>НИЙТ</b>	<b>4,939.9</b>	<b>4,110.7</b>	<b>-829.2</b>

Сум хөгжүүлэх сангаас (хуучин нэрээр) зээлд хамрагдсан зарим иргэд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, зээлийг хугацаа хэтрүүлсэн асуудлыг шүүхийн байгууллагад шилжүүлж, анхан шатны шүүхийн шийдвэр болон эвлэрүүлэн зуучлахаар гэрээ байгуулсан боловч зээл, зээлийн хүүг өнөөг хүртэл төлөөгүй байна.

Ажил хариуцсан албан тушаалтан хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх ажиллагаа явуулах хүсэлтийг шүүхэд гаргаагүйгээс хөөн хэлэлцэх хугацаа дуусаж, төсвийн хөрөнгө үргүйдэх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна.

Одоогийн байдлаар шүүхийн шийдвэр гарснаас хойш 3-аас дээш жил болсон зээлдэгчийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т зааснаар 47 иргэний 374.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсэх боломжгүй болоод байна.

Иймд орон нутгийн болон холбогдох байгууллагын удирдлагууд хамтран хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах санал хүсэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлэн, зээлд хамрагдаж эргэн төлөлт хийгээгүй иргэдийн гэрээний үүргийг хангуулах шаардлагатай байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Авлагатай холбоотой аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 201.2 сая төгрөгийн 9 илрүүлэлт хийгдсэнээс 146.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх 54.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэв. Илэрсэн алдаа зөрчлийг ангилан авч үзвэл:

- Мөнххаан, Сүхбаатар сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн гэрээний хугацаа дууссан боловч зээлийн үндсэн төлөлт болон хүүгийн 49.7 сая төгрөгийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй;
- Асгат, Дарьганга сумдын ОНХС, Онгон сумдын ЗДТГ, Хайлааст голомт ОНӨААТҮГ олон жилийн насжилттай 10.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй;
- Сүхбаатар, Наран сумын ЗДТГ 18.1 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд илэрхийлж, байгууллагын ил тод, найдвартай байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл үүсгэсэн;

• Дөрвөлж ОНӨААТҮГ харилцагч байгууллагаас авах 123.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлэн баталгаажуулаагүй, гэрээний дагуу төлбөр, тооцоог барагдуулаагүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр олгосон зээлийн зарим гэрээний хэрэгжилт хангагдаагүй, анхан шатны хариу арга хэмжээ аваагүйгээс авлага барагдуулах хууль зүйн боломж хязгаарлагдаж, хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдлууд бүртгэгдсэн байна.

Авлагын бүртгэл, баталгаажуулалт, гэрээний хяналт, хэрэгжилтийн хариуцлага сул байгаагаас зээлийн эргэн төлөлт хойшлогдож, зарим тохиолдолд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөх боломжгүй болсон нь төсвийн хөрөнгийн үр ашиг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлж байна.

Иймд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авлага барагдуулах ажиллагааг эрчимжүүлж, эрх зүйн зохицуулалтад дээд шатны байгууллагын оролцоотойгоор бодлогын түвшний шийдвэр гаргах шаардлагатай байна.

### 4.3 Бараа материал

Бараа материал дансны эхний үлдэгдэл 3,565.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,847.1 сая төгрөг болж, 281.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	74.8	114.4	39.6
Дуусаагүй үйлдвэрлэл	395.3	172.5	(222.7)
Бэлэн бүтээгдэхүүн	22.8	27.6	4.8
Хангамжийн материал	2,443.9	3,020.9	577.0
Биологийн хөрөнгө	148.3	200.8	52.5
Мал амьтад	397.0	202.4	(194.6)
Нөөцийн бараа	83.8	108.5	24.7
<b>Дүн</b>	<b>3,565.9</b>	<b>3,847.1</b>	<b>281.3</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	2,759.7	2,840.4	80.7
ОНӨҮГ	806.2	1,006.8	200.6
<b>Дүн</b>	<b>3,565.9</b>	<b>3,847.1</b>	<b>281.3</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд худалдан авсан 9,366.3 сая, үнэ төлбөргүй буюу хандив, тусламжаар 895.9 сая, шилжүүлэн авсан 26.9 сая, бусад 401.5 сая, нийт 10,772.7 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 9,638.3 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 283.1 сая төгрөгийг шилжүүлж, бусад 570.0 сая нийт 10,491.4 төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 74 хувийг төсөвт байгууллага, 26 хувийг ОНӨААТҮГ эзэлж байна.

Бараа материалын данс өмнөх оноос өссөн боловч, дуусаагүй үйлдвэрлэлийн данс 222.7 сая төгрөгөөр, мал амьтдын данс 272.8 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Мал амьтдын данс буурсан нь байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйлсийн улмаас малын зүй бус хорогдол гарсантай холбогдож байгаа бол, дуусаагүй үйлдвэрлэлийн данс буурсан нь Асгат, Онгон сумдын ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн 5 төсөл арга хэмжээний үндсэн хөрөнгийг тухайн ЗДТГ-ын дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Баруун-Урт сумын ЗДТГ-ын бараа материалын дансанд 172.5 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу байснаас шалтгаалан, тус дансанд үлдэгдлээр илэрхийлэгдсэн байна.

Хангамжийн материал данс өмнөх оноос 340.6 сая төгрөг буюу 16.2 хувиар нэмэгдсэн бөгөөд энэ нь хөрөнгийн шинж чанартай аж ахуйн зориулалттай материал худалдан авч данс бүртгэлд бүртгэсэнтэй холбоотой байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Бараа материалтай холбоотой нийт 1,267.8 сая төгрөгийн илрүүлэлтээс 1.3 сая төгрөгийн алдааг залруулж, 4.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,255.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх 6.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, дотоод хяналт, санхүүгийн сахилга бат, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалттай холбоотойгоор 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

- *Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 925.6 сая төгрөгийн нөөцийн өвс, тэжээл болон өвөлжилт хүндэрч гамшгийн байдалд хүрсэнтэй холбоотойгоор аж ахуйн нэгж байгууллагаас хандив, тусламж үзүүлсэн 255.8 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй /Аймгийн Засаг даргын хөтөлбөр, үйл ажиллагааны зардал, Түвшинширээ сумын ЗДТГ/;*
- *Тээвэр шатахууны зардлын 2.5 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй үлдэгдлээр илэрхийлсэн, бараа материалын тайланг 6.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. /Сүхбаатар сумын ЗДТГ/*
- *Байгалын давагдашгүй хүчин зүйл болох зуднаар үрээгдсэн 74.0 сая төгрөгийн хонь, ямааг бараа материалын холбогдох дансанд үлдэгдлээр бүртгэсэн. /Уулбаян сумын ЗДТГ/*
- *Бэлэн байдлын материал /гал унтраах цохиур 50ш, бээлий 100ш/-ыг 2.2 сая төгрөгөөр худалдан авсан гэх боловч хээрийн түймэр дахин гараагүй байхад материалыг шаардах хуудасгүйгээр зарлагадсан. / Түвшинширээ сумын ЗДТГ/ байна.*

**Бараа материалын бүртгэл, зарцуулалттай холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодит байдал алдагдаж, зарим хөрөнгийн ашиглалт, хяналт хангалтгүй хэрэгжсэн байна. Тухайлбал, зарим материаллаг хөрөнгийг бүртгэлд тусгалгүй зарцуулсан, шаардлагагүйгээр их хэмжээгээр нөөцөлсөн, анхан шатны баримтгүйгээр зарлагадсан, биетээр байхгүй хөрөнгийг үлдэгдлээр илэрхийлсэн нь дотоод хяналтын сул талыг илтгэж, тайлангийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулжээ.**

### **4.4 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 15.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 154.7 сая төгрөг болж, 139.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №7. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	15.1	149.2	134.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	20.0	5.5	(14.5)
<b>Дүн</b>	<b>35.1</b>	<b>154.7</b>	<b>119.6</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
<b>ТӨҮГ болон ОНӨҮГ</b>	15.1	154.7	139.6
<b>Дүн</b>	<b>15.1</b>	<b>154.7</b>	<b>139.6</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэл өсөхөд Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 9.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн НӨАТ-ын хувь тэнцүүлэлт болон Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 139.7 сая төгрөгийн шугам сүлжээний ажлыг үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэр хараахан гараагүй тул нийт 149.1 сая төгрөгийг урьдчилгааны дансанд бүртгэсэн нь голлон нөлөөлсөн.

#### 4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 73,051.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 75,354.2 сая төгрөг болж, 2,302.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	50,007.9	53,764.2	3,756.3
Хуримтлагдсан элэгдэл	(13,987.8)	(16,786.7)	(2,798.9)
Тээврийн хэрэгсэл	11,140.4	12,530.1	1,389.7
Хуримтлагдсан элэгдэл	(4,806.3)	(5,954.8)	(1,148.5)
Машин тоног төхөөрөмж	13,104.3	14,545.3	1,441.0
Хуримтлагдсан элэгдэл	(7,272.7)	(8,854.1)	(1,581.4)
Тавилга эд хогшил	2,285.7	2,869.8	584.1
Хуримтлагдсан элэгдэл	(1,442.3)	(1,351.1)	91.2
Зам гүүрийн байгууламж	754.8	781.8	27.0
Хуримтлагдсан элэгдэл	(162.7)	(221.1)	(58.4)
Дуусаагүй барилга байгууламж	822.0	822.0	0.0
Номын фонд	0.4	0.4	0.0
Бусад үндсэн хөрөнгө	24,023.7	26,305.9	2,282.2
Хуримтлагдсан элэгдэл	(10,276.4)	(12,064.8)	(1,788.4)
Программ хангамж	212.1	217.3	5.2
Хуримтлагдсан элэгдэл	(43.4)	(33.3)	10.1
Бусад биет бус хөрөнгө	8,691.8	8,767.4	75.6
Хуримтлагдсан элэгдэл	(8.4)	(12.8)	(4.4)
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	<b>8.7</b>	<b>28.7</b>	<b>20.0</b>
<b>ДҮН</b>	<b>73,051.8</b>	<b>75,354.2</b>	<b>2,302.4</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
<b>Төсөвт байгууллага</b>	36,068.0	35,576.3	(491.7)
<b>ТӨҮГ болон ОНӨҮГ</b>	36,983.8	39,777.9	2,794.1
<b>ДҮН</b>	<b>73,051.8</b>	<b>75,354.2</b>	<b>2,302.4</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 47 хувийг орон нутгийн төсөвт байгууллагууд, 53 хувь ОНӨААТҮГ-ын хөрөнгүүд эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 890.3 сая, үнэ төлбөргүй хандив, тусламжаар 1,357.0 сая, шилжүүлэн авсан 5,233.5 сая, бусад 4,700.9 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 832.7 сая нийт 13,014.4 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 4,0 сая, балансаас баланст шилжүүлсэн 729.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 2,031.8 сая, акталсан 310.5 сая, дахин үнэлгээний хорогдол 130.1 сая, бусад 130.1 нийт 3,433.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн шалтгааныг данс тус бүрээр тодруулж үзэхэд дараах үр дүн илэрхийлэгдэж байна. Үүнд:

- **Барилга, байгууламж данс** 4,479.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хүлээн авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгасантай холбоотой. Үүнд: Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан, Асгат зэрэг сумдад наадмын талбай, шугам сүлжээ, цамхаг гэрэл, худаг, дэд станц, авто замын гэрэлт гарц зэрэг барилга байгууламжууд багтсан.
- **Тээврийн хэрэгсэл данс** 1,717.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд орон нутгийн болон бусад эх үүсвэрээр автобус, пикап, ковш зэрэг нийт 7 тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн нь нөлөөлсөн.
- **Бусад хөрөнгө данс** 2,282.2 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт үлдэгдэл 26,305.9 сая төгрөгт хүрсэн. Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн худаг, тоглоомын талбай, гэрэлтүүлэг, хүлэмж зэрэг жижиг хэмжээний бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгасантай холбоотой.

Дуусаагүй барилга байгууламж дансанд Халзан сумын сайжруулсан авто зам 244.0 сая, Баруун-Урт сумын 578.0 сая төгрөгийн үерийн ус зайлуулах сувгийн байгууламж улсын комисс хүлээн аваагүй хөрөнгүүд бүртгэлтэй байгаа нь гүйцэтгэгч байгууллага хариуцсан ажлаа дутуу дулимаг, чанаргүй хийх, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулах эрсдэлд хүргэж, санхүүгийн хяналт, хариуцлагыг алдагдуулж байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 225.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 8 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

- *Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа боловч дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. /Баяндэлгэр, Уулбаян, Эрдэнэцагаан сумдын ЗДТГ, Халзан сумын ИТХ/*
- *Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй /Баяндэлгэр, Уулбаян сумдын ЗДТГ/*

**Тайлант онд хүлээн авсан дуусаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж аваагүй нь гүйцэтгэгч байгууллагын чанаргүй гүйцэтгэл, хяналт, хариуцлагын нөхцөл байдлаас үүссэн.**

**Мөн ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй нь хөрөнгийн үнэлгээг зөрүүтэй илэрхийлэх, шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Дээрх асуудлыг шийдвэрлэхэд батламж мэдэгдлийг хангуулах шаардлагатай бөгөөд санхүүгийн хяналт, бүртгэлд ил тод, бодитой байдал үүсгэх, шийдвэр гаргалтад нөлөөлөх эрсдэлийг бууруулахад анхаарах шаардлагатай байна.**

#### 4.6 Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 23,322.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 23,646.9 сая төгрөг болж, 314.3 сая төгрөгөөр өссөн нь голлон ОНӨҮГ-уудын үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг НББОУС-20-т заасны дагуу хойшлогдсон орлого дансанд бүртгэснээс үүдэлтэй байна. Энэ нь өр төлбөрийн үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

<i>Хүснэгт №9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл</i>			
	<i>/сая төгрөг/</i>		
<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>Өссөн буурсан</b>
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>23,332.6</b>	<b>23,646.9</b>	<b>314.3</b>
Богино хугацаат зээлийн өглөг	663.3	642.2	(21.1)
<b>Өглөг</b>	<b>1,668.4</b>	<b>1,394.6</b>	<b>(273.8)</b>
Ажиллагчидтай холбогдсон өглөг	84.5	94.4	9.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	58.4	3.8	(54.6)
Бусад өглөг	1,525.5	1,296.3	(229.2)
Байгууллагад төлөх өглөг	1,201.5	906.7	(294.8)
Хувь хүмүүст төлөх өглөг	32.9	91.6	58.7
Татварын өглөг /ТӨҮГ/	178.1	115.2	(62.9)
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	19.8	27.2	7.4
Дансны өглөг /ТӨҮГ/	93.2	155.5	62.3
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>21,000.9</b>	<b>21,610.1</b>	<b>609.2</b>
Бусад урьдчилж орсон орлого	20,178.4	20,806.3	627.9
ТӨҮААГ	822.5	803.8	(18.7)
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>12,814.5</b>	<b>12,581.8</b>	<b>(232.7)</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	12,814.5	12,580.3	(234.2)
<b>Нийт дүн</b>	<b>36,147.1</b>	<b>36,228.7</b>	<b>81.6</b>
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>23,332.7</b>	<b>23,646.9</b>	<b>314.2</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			0.0
Төсөвт байгууллага	466.6	665.3	198.7
Төрийн сан	509.1	148.8	(360.3)
ТӨҮГ болон ОНӨҮГ	22,357.0	22,832.9	475.9
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>12,814.5</b>	<b>12,814.5</b>	<b>0.0</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,575.2	1,342.4	(232.8)
Төсөвт байгууллага	11,239.3	11,239.3	0.0
<b>Нийт дүн</b>	<b>36,147.2</b>	<b>36,228.7</b>	<b>81.5</b>

Урт хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 12,814.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,581.8 сая төгрөг болж, 232.7 сая төгрөгөөр буурчээ.

Энэ нь Азийн хөгжлийн банкнаас Баруун-Урт сумын халаалт, цэвэр бохир усны шугамын ажилд урт хугацаат зээл олгосон бөгөөд түүний эргэн төлөлтөд 2022 онд 2,589,1 сая, 2023 онд 232,0 сая, 2024 онд 232.0 сая төгрөг тус тус төлсөн бөгөөд одоогоор 1,341.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд Баруун-Урт сумын төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын эцсийн гүйцэтгэлийг хүлээн авснаас урт хугацаат өр төлбөр үүссэн байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Өр төлбөртэй холбоотой нийт 770.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн. Илэрсэн зөрчлийг байгууллага тус бүрээр авч үзвэл.Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27 төсөл арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцаа 746.3 сая төгрөгийг зардал, өглөгөөр бүртгэж, тайлагнаагүй. /Баруун-Урт сумын ХХС, аймгийн Авто замын сан, аймгийн ОНХС/
- Эзэн холбогдогч нь тодорхой 0.4 сая төгрөгийн өглөгийг он удаан жил тайланд тусгасан./Баруун-Урт сумын ХХС/
- Өр төлбөрийг зохистой удирдаж ажиллаагүйгээс санхүүгийн тайланд 14.9 сая төгрөгийн өглөг бий болгосон, санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй ажлын хөлсөнд 9.0 сая төгрөг олгож, уг зардлыг тайлант хугацаанд бүртгэсэн. /Онгон сумын ЗДТГ/

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27 төсөл арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцааг зардал, өглөгөөр бүртгэж тайлагнаагүй нь санхүүгийн тайланд бодит байдлыг зөрчиж, хяналт сулруулах эрсдэл үүсгэж байна.**

**Баруун-Урт сумын ХХС-ийн өглөгийг удаан хугацаагаар тайланд тусгасан нь санхүүгийн үнэн зөв байдал алдагдуулж, өглөгийн удирдлагад сул орон зай үүсгээд байна.**

**Онгон сумын ЗДТГ нь өр төлбөрийг зохистой удирдаж ажиллаагүйгээс өглөг үүссэн нь санхүүгийн тайлангийн найдвартай байдалд эргэлзээ үүсгэж байна. Түүнчлэн, ажлын хөлсийг тайлагнаагүй нь санхүүгийн зарцуулалтад зөрчил гаргаж, удирдлагын хяналт болон санхүүгийн хариуцлагыг алдагдуулах нөхцөл үүсгэж байна. Эдгээр ажил гүйлгээ, илэрсэн асуудлууд нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.**

### **4.7 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 86,721.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 98,873.3 сая төгрөг болж 12,152.3 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн + Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал	34,606.8	34,647.3	40.5
Өмч /ТӨҮГ/	2,956.0	4,945.1	1,989.1
Эздийн өмчийн бусад хэсэг	236.9	236.9	-
Хуримтлагдсан үр дүн	38,848.4	48,968.9	10,120.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,072.9	10,072.9	-
<b>Дүн</b>	<b>86,721.0</b>	<b>98,871.1</b>	<b>12,150.1</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо данс өмнөх оноос өссөн нь тайлант онд 12,069.8 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан бөгөөд хуримтлагдсан үр дүн 10,120.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үр дүнтэй ажиллах болсон шалтгаан нь төсвийн байгууллагад үнэ төлбөргүйгээр хүлээн авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой юм.

#### 4.8 Орлогын данс

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны орон нутгийн төсвийн татварын орлогыг 42,477.8 сая, татварын бус орлогыг 8,505.2 сая, хөрөнгийн орлогыг 120.0 сая нийт 51,103.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр татварын орлого 42,477.3 сая, татварын бус орлого 4,814.2 сая, хөрөнгийн орлого 102.1 сая нийт 42,477.3 сая төгрөгийн орлого төвлөрчээ. Үүнээс татварын орлогын гүйцэтгэл 88.4 хувь, татварын бус орлого 56.6 хувь нийт дүнгээр 83.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №11 Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1	2	/2-1/	/2:1/
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>51,103.0</b>	<b>42,477.3</b>	<b>(8,625.7)</b>	<b>83.1</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>42,477.8</b>	<b>37,561.0</b>	<b>(4,916.8)</b>	<b>88.4</b>
Хүн амын орлогын албан татвар	15,527.3	17,868.8	(2,472.8)	115.1
ААН-ын орлогын албан татвар	17,000.0	9,584.2	(7,415.8)	56.4
Өмчийн татвар	1,296.7	1,814.6	517.9	139.9
Хөрөнгийн албан татвар	2,670.2	2,480.4	(189.8)	92.9
Бусад татвар /төлбөр хураамж/	330.7	183.8	(146.9)	55.6
Улсын тэмдэгтийн хураамж	101.1	445.8	344.7	440.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	229.6	173.7	(55.9)	75.7
Газрын төлбөр	4,623.0	2,657.6	(1,965.4)	57.5
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,363.8	1,958.3	594.5	143.6
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,625.2</b>	<b>4,916.3</b>	<b>(3,708.9)</b>	<b>57.0</b>
Хүү, торгуулийн орлого	3,123.0	1,755.3	(1,367.7)	56.2
Бусад орлого	5,382.2	3,058.9	(2,323.3)	56.8
Хөрөнгө худалдсаны орлого	<b>120.0</b>	<b>102.1</b>	<b>(17.9)</b>	<b>85.1</b>

Татварын болон татварын бус орлогоос 3 төрлийн орлого 1,457.1 сая төгрөгөөр давж, 8 төрлийн орлого 15,937.7 сая төгрөгөөр тасарсан байна. **Татварын болон**

татварын бус орлогын давсан, тасарсан шалтгааныг Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээс үзнэ үү.

#### Аудитын илрүүлэлт:

Орлого данстай холбоотой нийт 50.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 44.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 6.5 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

Орон нутгийн өмчийн 16.2 сая төгрөгийн түрээсийн орлогын 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй. /Уртын гэгээ, Чоно гол ОНӨААТҮГ/

#### 4.9 Зардал

Тайлант оны зардал 70,013.9 сая төгрөг болж өмнө оноос 15,023.3 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/ Өссөн +, Буурсан -
Бараа, ажил үйлчилгээний зардал	83,221.9	66,058.2	(17,163.7)
Татаас	70.5	1,429.2	1,358.7
Урсгал шилжүүлэг	877.7	2,490.8	1,613.1
Хөрөнгийн зардал	867.2	35.7	(831.5)
<b>Дүн</b>	<b>85,037.3</b>	<b>70,013.9</b>	<b>(15,023.4)</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	46,527.4	60,458.9	13,931.5
Төсөл, сан	30,414.1	473.7	(29,940.4)
Төрийн сан	55.3	130.5	75.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	8,040.5	10,928.9	2,888.4
<b>Дүн</b>	<b>85,037.3</b>	<b>70,013.9</b>	<b>(15,023.4)</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Бараа, ажил үйлчилгээний зардал:** Тухайн зардал тайлант онд 17,163.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн 29,255.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээг үр дүнгийн тайлангийн орлого, зардалд тус тус илэрхийлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа, ажил үйлчилгээний зардал нийт дүнгээр буурсан хэдий ч Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлсэн, төрийн зарим үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, жагсаалтыг шинэчилсэн, орон нутгийн нэмэгдэл олгосноор цалин хөлс, нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 51 хувиар буюу 6,655.7 сая төгрөгөөр өссөн байна. Мөн улсын төсвийн байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал орон нутаг хариуцах хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд өмнөх оноос 9 дахин буюу 8,125.5 сая төгрөгөөр өссөн байна.

**Татаас:** Тайлант онд ОНӨААТҮГ-уудад нийт 1,278.2 сая төгрөг, Ахмадын хороо 101.0 сая, Улаан загалмай Сүхбаатар салбар 50.0 сая, нийт 1,429.2 сая төгрөгийн татаас санхүүжилт олгосон байна.

**Урсгал шилжүүлэг:** Урсгал шилжүүлэг 2,490.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,358.7 сая төгрөгөөр өссөн нь 2024 оноос төрийн захиргааны албан хаагчдад орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгож эхэлсэн болон орон нутгийн сонгуулийн үр дүнгээс шалтгаалан чөлөөлөгдсөн улс төрийн албан тушаалтнуудад тэтгэмж олгосон нь нөлөөлжээ.

**Хөрөнгийн зардал:** Хөрөнгийн зардал өмнөх оноос 835.5 сая төгрөгөөр буурч 35.7 сая төгрөг болсон байна. Энэ нь өмнөх онд сумдын авто машины парк шинэчлэлттэй холбоотойгоор буурсан үзүүлэлттэй байна.

### **Аудитын илрүүлэлт:**

*Зардлын данстай холбоотой нийт 254.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 24.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 197.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 31.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүллээ. Үүнд:*

- Цалин, нэмэгдэл, урамшууллыг 26.8 сая төгрөгөөр зөрчилтэй бодож олгосон. /Сүхбаатар аймгийн ЗДТГ, Худалдан авах ажиллагааны газар, Наран, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумдын ЗДТГ/
- Тайлант онд цалингийн зардлаас нийт 15.8 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан. /Асгат, Баяндэлгэр сумын ЗДТГ/
- Албан томилолтын нөхөн олговрыг 0.3 сая төгрөгөөр дутуу бодож олгосон. /Нийтлэг ОНӨААТҮГ/
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан хоолны зардлыг 6.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. /Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ/
- Албан томилолтоор ажилласан зарим албан хаагч нарт 37.9 сая төгрөгийн хоолны зардал гарсан. /Уулбаян, Эрдэнэцагаан, Асгат сумын ЗДТГ, Баяндэлгэр, Уулбаян сумын ИТХ, Сүхбаатар аймгийн ИТХ/
- Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны 4 дүгээр тогтоолыг дагаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай Ардчилсан намд 20.0 сая төгрөгийн суудлын мөнгө олгосон. /Сүхбаатар аймгийн ИТХ/
- Ажил үйлчилгээ болон худалдан авалт хийгдээгүй байхад 11.2 сая төгрөгийг бэлтгэн нийлүүлэгч рүү шилжүүлэн төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна. /Наран сумын ЗДТГ, Халзан сумын ИТХ/
- Үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 131.8 сая төгрөгийн зарцуулалт гаргасан. /Сүхбаатар аймгийн ИТХ, Уулбаян, Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдын ЗДТГ, Мөнххаан сумын ХХС/

**Төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчдад олгосон цалин, урамшуулал, нөхөн олговрыг зохисгүй зарцуулсан нь санхүүгийн хяналт, хариуцлагын тэнцвэрийг хангаагүй илтгэж байна. Тухайлбал, үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгох, түр орлон гүйцэтгэж буй албан хаагчдад цалингийн зөрүү олгох, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгох зэрэг нь төсвийн зориулалтыг зөрчиж, зохих журмаар баталгаажуулаагүй зардлууд гарсан.**

**Мөн албан томилолтын зардал хэтрүүлэн зарцуулсан, хоолны хөнгөлөлт, суудлын мөнгө, мөн зориулалтгүй болон үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй зарцуулалт хийсэн нь төсвийн үр ашгийг бууруулж, төрийн санхүүгийн удирдлагад эрсдэл үүсгэж байна.**

**Эдгээр ажил гүйлгээ, илэрсэн асуудлууд нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна**

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлээр ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,163.7 сая, хандив тусламж 497.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 717.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,649.8 сая нийт 4,028.4 сая төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэл 435.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Тухайлбал нэмэлтийн дансны зарцуулалтыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 48.5 сая
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4.5 сая
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 18.6 сая
- Хангамж, бараа материалын зардалд 233.5 сая,
- Нормативд зардалд 10.5 сая,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 65.2 сая,
- Томилот, зочны зардалд 20.8 сая,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 723.6 сая,
- Бараа үйлчилгээний бусад зардалд 1,996.4 сая,
- Урсгал шилжүүлэг 903.4 сая,
- Хөрөнгийн зардал 29.0 сая төгрөг нийт 4,025.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### 4.10 Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил, залруулга

##### Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргав.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 13 сумын Засаг дарга, 66 төсвийн байгууллага, 21 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага нийт 100 санхүүгийн тайлан нэгтгэгдэж аудитад хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагаас 76 байгууллагыг түүвэрт хамруулж, 24 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнээс 20 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 3 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Дүгнэлт гаргахаас татгалзсан” дүгнэлт өгөв.

*Хүснэгт № 13 “Өөрчлөлттэй” дүгнэлт өгсөн байгууллага*

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
<b>“ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ”</b>	
Наран сумын Засаг дарга /ТТЗ/	Төсвийн хөрөнгөөс хийгдээгүй ажлын урьдчилгаа олгосон, Засаг даргын нөөц сангаас хөрөнгө худалдан авсан, наадмын талбайн засвар, тохижилтын ажлын зураг, төсөв боловсруулах гэрээний дагуу ажил бүрэн

	дуусаагүй, хүлээж аваагүй байхад төлбөрийг бүрэн шилжүүлсэн
Түвшинширээ сумын Засаг дарга /ТТЗ/	Улсын нөөц болон аймгийн аюулгүйн нөөцөөс олгосон өвс, тэжээл, хивэг, хүнсний бүтээгдэхүүн, нүүрс зэрэг тусламжийн материалыг санхүүгийн тайланд бүртгэлгүйгээр зарцуулсан, бэлтгэн нийлүүлэгч рүү шилжүүлсэн ажил гүйлгээний дүнгээс төсөв захирагчийн хувийн данс руу шилжүүлсэн, нярвын хувийн дансаар дамжуулан ажил гүйлгээ хийсэн.
Уртын гэгээ ОНӨААТҮГ	Бэлтгэн нийлүүлэгч рүү шилжүүлсэн ажил гүйлгээний дүнгээс төсөв захирагчийн хувийн данс руу шилжүүлсэн, хамаарал бүхий этгээдийн компанийн данс руу мөнгө шилжүүлж ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй, бараа, ажил, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, тендер сонгон шалгаруулалт зарлахаас зайлсхийж төсөвт өртгийг хэсэгчлэн худалдан авалт хийсэн.

**“ДҮГНЭЛТ ГАРГАХААС ТАТГАЛЗСАН”**

Бичигт хөгжил ОНӨААТҮГ	Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, тайлангийн ажил гүйлгээг хангалттай болон зохистой нотлох баримтаар дэмжээгүй, 2024 оны зорилтот түвшин, эдийн засгийн үзүүлэлтүүдийг батлуулаагүй, 2024 оны наймдугаар сараас хойш үйл ажиллагаа тасалдаж, тухайн байгууллагын захирал үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн.
------------------------	--

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллагуудад нийт 3,729.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 366.4 сая төгрөгийн алдааг залруулж, 65.8 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 2,386.0 сая төгрөгийн зөрчилд 40 албан шаардлага, 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 911.5 сая төгрөгийн зөрчилд 51 зөвлөмж өгсөн.

**Алдаа, зөрчил илэрсэн байдлыг төсвийн захирагч тус бүрээр авч үзвэл:**

**Төсвийн шүүд захирагчийн хувьд:** Орон нутгийн төсвийн 66 байгууллагаас (төсөл, сан орсон дүн) 64 санхүүгийн тайланд үе шатны хяналт хэрэгжүүлсэн бол 2 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Аудитаар нийт 2,939.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 322.4 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 56.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,654.9 сая төгрөгийн зөрчил арилгах давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн бол албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 905.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн.

Төсвийн шууд захирагчийн хэмжээнд гарсан алдаа зөрчлийг өмнөх онуудтай харьцуулж үзэхэд алдаа зөрчил 2,272.8 сая төгрөгөөр буурсан байна. Алдаа зөрчлийн нэгтгэлийг харьцуулж харуулав:

*Хүснэгт №14 Төсвийн шууд захирагчийн зөрчлийн судалгаа (сая төгрөгөөр)*

Он	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох санал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2021	413	23,853.2	37	9,072.1	53	93.8	91	679.2	226	13,845.4	6	162.7
2022	134	4,550.3	5	122.4	20	58.8	59	4,172.8	48	196.3	2	-
2023	93	5,212.2	24	3,801.7	11	35.8	11	157.8	46	1,216.9	1	-

Төсвийн байгууллагын удирдлага, нягтлан бодох бүртгэлийн хариуцлагатай албан тушаалтнуудын бүртгэл, тайлангийн сахилга хариуцлага сул, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдал, хууль, журмын хэрэгжилтийг хангах хяналт дутмаг байгаагаас дараах нийтлэг алдаа дутагдал үргэлжилсээр байна. Үүнд: хандив, тусламжаар ирсэн бараа, материалыг бүртгэлд тусгаагүй, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, авлага, өглөгийг зохистой удирдаагүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, мөнгөн урамшууллаас татвар суутгаагүй зэрэг нь санхүүгийн тайлангийн бодит байдалд сөргөөр нөлөөлж, хууль тогтоомж зөрчих, төсвийн сахилга бат алдагдах, удирдлагын шийдвэр гаргалтад буруу мэдээлэл өгөх эрсдэл бий болгож байна.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд:** Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмж өглөө.

Алдаа зөрчлийн нэгтгэлийг харьцуулж харуулав:

*Хүснэгт №15 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн судалгаа (сая төгрөгөөр)*

Он	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2021	68	8,305.3	27	8,179.5	3	120.5	6		32	5.3
2022	15	603.9					2	23.7	13	580.2
2023	35	659.4	7	449.4			2	195.0	26	15.0
2024	13	-	-	-	-	-	-	-	13	-

**Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд:** Аудитаар нийт 790.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 44.1 сая төгрөгийн алдааг залруулж, 8.9 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 731.1 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 6.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгөв.

Аймгийн ОНӨААТҮГ-ын хэмжээнд гарсан алдаа зөрчлийг өмнөх онуудтай харьцуулж үзэхэд алдаа зөрчил 32.3 сая төгрөгөөр өссөн байна. Алдаа зөрчлийн нэгтгэлийг харьцуулж харуулав:

*Хүснэгт №16 ОНӨААТҮГ-ын зөрчлийн судалгаа (сая төгрөгөөр)*

Он	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох санал
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
2021	58	10,741.1	8	131.5	6	3.3	14	1,670.7	30	8,935.6	-
2022	48	2,614.4	7	2,172.3	6	8.2	16	417.3	19	16.6	-
2023	24	758.1	5	614.1	1	0.5	7	113.6	11	29.9	-
2024	21	790.4	2	44.1	3	8.9	6	731.1	7	6.3	3

Өмнөх онтой харьцуулахад зөрчил, алдаа нэмэгдсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор худалдан авах ажиллагааг шинэ хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, хэрэгжилтийг хангах бэлтгэл хангалтгүй, мэргэшсэн хүний нөөц, зохион байгуулалтын чадавх сул байсантай холбоотой байна. Энэ нь хууль зөрчих, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хариуцлага, хяналтын тогтолцоог алдагдуулах эрсдэлийг бий болгож байна.

## Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахтай холбоотой дараах алдаа гарсныг залрууллаа. Үүнд:

- Мөнххаан сумын ОНХС-ийн 328.4 сая, Сүхбаатар сумын ОНХС-ийн 1,649.6 сая нийт 1,978.0 сая төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал буруу бүртгэснийг дахин тулгалт хийж алдааг залруулсан.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:**

Сүхбаатар аймгийн Засаг даргын нэгтгэсэн тайланд үүссэн 260.0 сая төгрөгийн авлагыг харилцагч байгууллага болох “Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ-тай тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийн мэдээлэл зөрүүтэй, бодит байдлыг гажуудуулсан байдлаар тусгагдах нөхцөлийг бүрдүүлжээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” дахь заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Авлагыг баталгаажуулж, аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүллээ.

- Сүхбаатар аймгийн ЗДТГ, БОГ, ИТХ, СХДАА-ын хөрөнгөд бүртгэлтэй 9 дулаан зогсоол, 14 автомашины граж зэрэг нийт 221.5 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн ашиглалт, хадгалалтын байдалд зохих хяналтыг хэрэгжүүлэх шаардлага үүссэн бөгөөд эдгээр хөрөнгийн үр ашиггүй байдал, ашиглагдахгүй, бүртгэлд хөрөнгө байдлаар олон жил болж байна. Иймд ашиглалтыг сайжруулах, хэрэгцээтэй газруудад дахин хуваарилалт хийж, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг дээшлүүлэх нь зүйтэй байна.

*Хүснэгт 18. Дулаан зогсоол, автомашины гражын судалгаа /сая төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Дулаан зогсоол		Автомашины граж		Нийт	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
1	Сүхбаатар аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	9.8	2	2.2	3	12.0
2	Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар	5	49.0	10	119.9	15	168.9
3	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	19.6	1	5.6	3	25.2
4	Санхүүгийн хяналт, аудитын газар	1	9.8	1	5.6	2	15.4

<b>НИЙТ</b>	<b>9</b>	<b>88.2</b>	<b>14</b>	<b>133.3</b>	<b>23</b>	<b>221.5</b>
-------------	----------	-------------	-----------	--------------	-----------	--------------

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл**

Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газар нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,924.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4,521.5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. Залруулаагүй 5,402.5 сая төгрөгийн 135 алдаа зөрчлийн 36.2 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт, 278.1 сая төгрөгийн зөрчил арилгах 28 албан шаардлага өгч, 38.3 сая төгрөгийн 2 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 5,049.8 сая төгрөгийн зөрчилд 93 зөвлөмж өгсөн.

Жилийн эцсийн байдлаар 85.1 сая төгрөгийн 7 албан шаардлага, 10.3 сая төгрөгийн 7 зөвлөмж хэрэгжээгүй байна.

#### *Хүснэгт 17. 2024 оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

<b>Аудитын шийдвэр</b>		<b>Тоо</b>	<b>Дүн</b>	
<b>А</b>	<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	
<b>1</b>	<i>Албан шаардлага</i>	<i>ТТЗ</i>	<i>1</i>	<i>50.0</i>
		<i>ТБОНӨААН</i>	<i>4</i>	<i>21.7</i>
		<i>ТШЗ</i>	<i>2</i>	<i>13.4</i>
		<b>Дүн</b>	<b>7</b>	<b>85.1</b>
<b>2</b>	<i>Зөвлөмж</i>	<i>ТТЗ</i>	<i>1</i>	<i>-</i>
		<i>ТБОНӨААН</i>	<i>2</i>	<i>-</i>
		<i>ТШЗ</i>	<i>4</i>	<i>10.3</i>
		<b>Дүн</b>	<b>7</b>	<b>10.3</b>

Албан шаардлагын болох нийт 85.1 сая төгрөгийн үлдэгдэлд Баруун-Урт, Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумдын Засаг даргын Тамгын газар, Бичигт хөгжил ОНӨААТҮГ, Орон нутгийн хөгжлийн сан хамаарч байгаа бөгөөд тогтоосон хугацаанд хэрэгжилт хангагдаагүй байна. Иймд холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлэхээр төлөвлөж, сонсох ажиллагаа хийхээр ажиллагаа хийгдэж байна.

Мөнххаан хоршоо хөгжүүлэх сан, Бичигт хөгжил ОНӨААТҮГ, Сүхбаатар ойжуулалт ОНӨААТҮГ, Баруун-Урт сумын ОНХС-ийн зөвлөмжийн хэрэгжилт дутуу, Дарьганга сумын ОНХС-ийн олон жилийн насжилттай хувь хүнээс 5.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй тул албан шаардлага өгсөн, Асгат, Онгон сумын Засаг даргын тамгын газрын 2 зөвлөмж аудит гүйцэтгэлийн үед хэрэгжсэн байна.

## **5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ**

1. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зарим үзүүлэлт үнэн зөв, хууль тогтоомжийн дагуу бүртгэгдэж тайлагнасан боловч нягтлан бодох бүртгэлийн бодлого шинэчлэгдээгүй, дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй, санхүүгийн сахилга хариуцлагын тогтолцоонд системийн доголдол байгааг илтгэх зөрчлүүд илэрсэн болно.
2. Тухайлбал, 2009 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлого шинэчлэгдээгүй нь УСНББОУС болон салбарын заавар, журмын хэрэгжилттэй нийцэхгүйд хүргэж, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдалд эргэлзээ үүсгэх нөхцөл бүрдүүлсэн; шагнал, урамшуулал, ажил гүйлгээний баримт бүрдэл дутуу, төсвийн зарцуулалтыг хувийн дансаар дамжуулсан зэрэг зөрчил нь санхүүгийн хариуцлага, ил тод байдал, хууль ёсны ажиллагааг зөрчсөн байна.
3. Шагнал урамшууллаас ХХОАТ суутгаагүй, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу ажил гүйлгээ гаргасан, байгууллагын төсөв захирагч, нягтлан бодогч, нярав хамаарал бүхий этгээдийн хувийн харилцах дансаар дамжуулан зарцуулалт гаргаж санхүүгийн сахилга бат ил тод байдлыг алдагдуулах эрсдэл үүссэн.
4. Сум хөгжүүлэх сангаас зээлд хамрагдсан зарим иргэд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, зээлийг хугацаа хэтрүүлсэн асуудлыг шүүхийн байгууллагад шилжүүлж анхан шатны шүүхийн шийдвэр болон эвлэрүүлэн зуучлахаар гэрээ байгуулсан боловч зээл, зээлийн хүүг өнөөг хүртэл төлөөгүй байна
5. Хандив тусламжаар ирсэн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан нөөцийн өвсийг данс бүртгэлд тусгалгүй зарцуулсан.

### **5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

#### **СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-д**

1. Халзан сумын сайжруулсан авто зам 244.0 сая, Баруун-Урт сумын үерийн ус зайлуулах сувгийн байгууламж 578.0 сая, нийт 822.0 сая төгрөгийн улсын комисс хүлээн аваагүй хөрөнгүүд үндсэн хөрөнгө дансны дуусаагүй барилга байгууламжид 10-аас дээш жил бүртгэлтэй байгаа нь НББ-ийн стандартад нийцэхгүй байна. Иймд нөхцөл байдлыг тодруулж, холбогдох дээд шатны байгууллагад үүрэг, чиглэл өгч асуудлыг шийдвэрлүүлж ажиллах

2. Тайлант онд илэрсэн зөрчил, дутагдалд дүн шинжилгээ хийж, давтан гаргахгүй байх чиглэлээр төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, санхүүгийн удирдлага, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор Санхүү, хяналт, дотоод аудитын газраар эрсдэл нөхцөлүүдэд давтамжтай хяналт хийлгэж, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал, ил тод байдлыг сайжруулах арга хэмжээнүүдийг зохион байгуулах

#### СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА-д:

1. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал, өглөгийн бүртгэлд анхаарал хандуулж, гэрээний хэрэгжилт болон өр төлбөрийн удирдлагад ил тод байдал, хяналтыг сайжруулах, шаардлагатай тайланг цаг тухайд нь бүртгэж, санхүүгийн зарцуулалтыг зөв ангилж, хариуцлагын тогтолцоог чангатгах
2. Бараа материалын бүртгэл, зарцуулалтыг сайжруулж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, нөөцлөлт, зарцуулалтад хяналтыг чангатгах, хяналтгүй зарцуулалтаас зайлсхийх, материаллаг хөрөнгийн ашиглалт, хадгалалтын хяналтыг зохион байгуулан, тайлангийн үнэн зөв байдалд нөлөөлөх эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах
3. Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, олон улсын стандартын шинэчлэлтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, батлан хэрэгжүүлэх нь нэн шаардлагатай. Энэ нь бүртгэл хөтлөлт, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдал, ил тод байдлыг хангах, санхүүгийн тайлангийн үнэн зөв илэрхийлэл, хууль тогтоомжийн дагуу ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тул зөвлөж байна.

#### СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБА-д:

1. Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил арилахгүй байгаад дүгнэлт хийж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын чанар, үр дүнг сайжруулах

#### **Үндэсний аудитын газарт санал:**

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарим гэрээний хэрэгжилт хангагдаагүй, хугацаа хэтэрсэн тохиолдлыг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлж, анхан шатны шүүхийн шийдвэр болон эвлэрлийн гэрээ байгуулсан хэдий ч зээл, зээлийн хүү өнөөг хүртэл барагдаагүй байна.

Гүйцэтгэх ажиллагаа явуулах хүсэлтийг хуульд заасан хугацаанд шүүхэд гаргаагүйгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусаж, төсвийн хөрөнгө эргэн төлөгдөх боломжгүй болсон ноцтой нөхцөл байдал үүсээд байна. Тухайлбал, шүүхийн шийдвэр гарснаас хойш 3-аас дээш жил болсон 47 иргэний нийт 374.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүү нь шийдвэр гүйцэтгэх боломжгүй болсон байна.

Иймд зээлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах, төрийн мөнгөн хөрөнгийг үргүйдүүлэх эрсдэлээс сэргийлэх зорилгоор хууль эрх зүйн зохицуулалтад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Сангийн яам, Хууль зүй, дотоод

хэргийн яам зэрэг дээд шатны байгууллагад санал, хүсэлт уламжлуулах саналыг боловсруулж байна.



### 5.3 Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 7 дугаар баг, Баруун-Урт сум,  
Сүхбаатар аймаг, 22075 Утас: (976) 70518585  
Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn  
Цахим хуудас: www.sukhbaatar.gov.mn

2025.04.25 № 01/421

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Тайлбар хүргүүлэх тухай

Сүхбаатар аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөрчил гэж үзсэн асуудлуудад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 12 төсөл арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцаа 309,277.1 мянган төгрөгийг зардал, өглөгөөр бүртгэж, тайлагнаагүй.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 14 төсөл арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцаа 428,022.5 мянган төгрөгийг зардал, өглөгөөр бүртгэж, тайлагнаагүй.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцаа 9,000.0 мянган төгрөгийг зардал, өглөгөөр бүртгэж, тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1./Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө./, Төсвийн тухай хуулийн 26.1./Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө./, УСНББОУС 1 – "Санхүүгийн тайлагналын толилуулга"-ийн 80 дахь заалтыг тус тус зөрчсөн бөгөөд "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгааны барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд холбогдох дансанд төвлөрүүлэн авч үлддэг. Энэ хөрөнгийн бүртгэлийн хувьд шилжих хөрөнгө оруулалт гэж дараагийн төсвийн жилийн төсөвт тусган батлан хэрэгжүүлж ирсэн. Энэ тохиолдолд зардал, өглөгөөр бүртгэх шаардлагагүй гэж үзэж байна. Зардал, өглөгөөр бүртгэн үлдэгдлээр хадгалагдсан тохиолдолд гэрээт хугацаанд олгогдохгүй байх, хэд хэдэн жил үргэлжлэн хөрөнгө түгжигдэх зэрэг сөрөг үр дагаврууд гардаг.

Нөгөө талаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана. **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн** 4 дүгээр зүйлийн 4.1.1. "аж ахуйн нэгж" гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа

нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг; **Төсвийн тухай хуулийн** 4 дүгээр зүйлийн 4.1.34."төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг; 4.1.36."төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; гэж тус тус зааснаас үзвэл Засаг дарга данс, Замын сан, ОНХС зэрэг сангууд нь Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төсвийн тухай хуулийн үйлчлэлд дангаараа хамаарахгүй байхаар ойлгогдож байна. Иймээс 746,299,6 мянган төгрөгийг зөрчил гэж үзэхгүй байна. Бүртгэл сайжруулах асуудалтай санал нэг байгаа бөгөөд үүнийг оновчтой зөв байдлаар нэг мөр болгон шийдвэрлэх талаар судалж хамтран ажиллахыг та бүхнээс хүсэж байна.

Орон нутгийн төсвөөр худалдан авсан 840,000,000 төгрөгийн өвс, ОБЕГ-аас худалдан авсан 85,587,160 төгрөгийн тэжээл, Гандантэгчилэн хийдээс хандивласан 12,500,000 төгрөгийн хорголжин тэжээл, өвс, нэмнээ, Олгой булаг ХХК-иас хандивласан 65,748,800 төгрөгийн тээврийн зардалтай 2528.8 тонн нүүрс, МУЗГ, ОБЕГ, Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК, Төв аймгийн угтаал цайдам сум, Давхар даатгал ТӨХК зэрэг газраас нийлүүлэгдсэн 1,008.7 тонн тэжээл, 800.0 тонн улаан буудай, 147.0 тонн хивэг, 75.3 тонн гурил, будаа зэрэг материалыг холбогдох төсвийн байгууллагууд данс бүртгэлд тусгаж, зарцуулсан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2./бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; / Төсвийн тухай хуулийн 26.1./Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө./, УСНББОУС 1 – "Санхүүгийн тайлагналын толилуулга"-ийн 76 дахь заалтыг тус тус зөрчсөн бөгөөд "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2023 - 2024 оны өвөл, хавар тус аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарын хувьд дараалан гамшигт нөхцөл байдал үүсэж, нийт нутаг дэвсгэрийг хамарсан төмөр буюу мөсөн зудын байдалд өвөлжиж нийт 3.0 сая орчим толгой мал хорогдож иргэд байгууллагуудад үлэмж хэмжээний хохирол учирсан. Аймаг, орон нутгийн удирдлагуудын хувьд гамшигын хариу арга хэмжээг тухай бүр шуурхай авч, эрсдэл хохирол багатай даван туулахад анхаарлаа хандуулан ажиллаж ирсэн болно.

Монгол Улсын Засгийн газар, бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа материал, өвс, тэжээлийг холбогдох шийдвэрийг гарган хуваарилан хүргүүлэхийн зэрэгцээ энэхүү хөрөнгө нь тухайн зорилтот эзэндээ очсон эсэх, үнэ нэмж иргэдийг хохироохгүй байх тал дээр онцгойлон анхаарч холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгч хяналт тавиулан ажилласан. Хүлээн авагч байгууллагуудын хувьд хууль тогтоомжийн хүрээнд данс бүртгэлдээ тусгаж зориулалтын дагуу зарцуулж ажиллах үүрэгтэй гэж үзсэн учир албан шийдвэр гаргаж үүрэгжүүлээгүй асуудал байгааг үгүйсгэхгүй байна. Гэхдээ сумд, байгууллагуудын төсөв захирагч, бүртгэл тооцооны ажилтнуудад сануулж хэлж байсан болно. Сумдууд бүртгэлд тусган зарцуулсан гэсэн мэдээллийг өгч байсан байна. Аймгийн нөөцөд худалдаж авсан өвс бүгд хуваарилагдсан, тэжээлийн хувьд ХХААГ дээр 300 шуудай үлдэгдэлтэй байна болно.

Иймд танай байгууллагын зүгээс дээрх өвч, тэжээлийг бүртгэлд тусгаагүй гэж албан шаардлага хүргүүлсэн Түвшинширээ сумаас бусад төсвийн захирагчид бүртгэлдээ тусган

зарцуулсан гэж ойлгож байна. Аймгийн нөөцөд худалдаж авсан өвс бүгд хуваарилагдсан, Цаашид энэ чиглэлээр сумдад болон байгууллагуудад чиглэл өгч хяналт тавихын зэрэгцээ Засаг даргаас гарах шийдвэрүүдэд тусган ажиллах болно. Мөн аймгийн гамшиг ослын үед болон аюулгүйн нөөцийн хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалтын асуудлын хариуцагчийг тодорхой болгон шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ. Иймээс 1,003,835,960 мянган төгрөгийг зөрчил гэж үзэхгүй байна.

Төсвийн тухай хуульд зааснаар 4.1.36."төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; гэж заасан байдаг бөгөөд сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай адил эрх, үүрэг бүхий төсвийн ерөнхийлөн захирагчид байдаг. Мөн Уртын гэгээ ОНӨҮГазар нь Баруун-Урт сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяанд үйл ажиллагаа явуулдаг. Төсвийн тухай хуульд 4.1.39."төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч" гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг; гэж зааснаар үйл ажиллагаа эрхэлж төсвөөс санхүүжилт авдаг. Түвшинширээ, Наран сумдын төсвийн ерөнхийлөн захирагчид болон Уртын гэгээ ОНӨҮГазар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 940,414,700 төгрөгийн зөрчил илэрч "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан бөгөөд энэ зөрчлийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид давхар тооцож зөрчлийн хэмжээг нэмэгдүүлсэн байх нөхцөл гэж үзэж байна. Төсвийн захирагчид бол хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тогтоосон эрх, үүрэгтэй хуулийн этгээдүүд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нь тэдний төсөв, санхүүгийн бүх үйл ажиллагаанд оролцох, өдөр тутам хянах боломжгүй байдаг.

Ийм учир дурдагдсан асуудлууд нь талуудад зөрүүтэй ойлгогдож байгаа, хариуцагч нь тодорхойгүй хөрөнгийн бүртгэлийн асуудлыг тодорхой болгосон шийдвэр гарч байгаа болон хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, амьдрал дээр үүссэн нөхцөл байдал зэргийг харгалзан дээрх 2,690,550,260 төгрөгийн дүнг зөрчлийн бүртгэлээс хасуулж материаллаг байдлын түвшний тооцоололд харгалзан үзэх саналыг уламжилж байна.



М.ИДЭРБАТ

#### 5.4 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:

#### Аймгийн Засаг даргын ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	<p>Хөрөнгө оруулалтын ТАХ-ий чанарын баталгаат хугацааны барьцаа 743.3 сая төгрөгийг зардал, өглөгөөр бүртгэж тайлагнаагүй нь бүртгэл, тайлагналтай холбоотой залруулагдаагүй алдаа бөгөөд шинж чанарын хувьд материаллаг гэж үзэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, Төсвийн тухай хуулийн 6.3.2 “.санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;”, 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, УСНББОУС-ын “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ын 80, 81 дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.</p>
Тайлбар 2	<p>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 925.6 сая, бусад байгууллага, аж ахуйн нэгжээс хандив тусламжаар ирсэн 78.2 сая нийт 1,003.8 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаж, зарцуулалтад хяналт тавьж, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаагүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, Төсвийн тухай хуулийн 6.3.2 “.санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;”, 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, УСНББОУС-ын “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ын 76 дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.</p>
Тайлбар 3	<p>Нэгтгэсэн тайлангийн материаллаг алдаа, зөрчил нь нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг боловч өргөн тархаагүй тул АДБОУС 200.78 “аудитор санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхдээ түүний бүрэлдэхүүн тайлангуудын санхүүгийн мэдээлэл, нэгтгэлийн үйл явцын найдвартай байдлын талаар хангалттай, зохистой нотолгоо бүрдүүлнэ”, АДБОУС 2700.17 “аудитор олж авсан аудитын нотолгоонд үндэслэн санхүүгийн тайланг бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй гэж үзэх боломжгүй, хамрах хүрээний хязгаарлалттай тохиолдолд аудиторын тайлангийн дүгнэлтийг өөрчилж болно” стандартын дагуу аймгийн Засаг даргын нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл үүссэн байна.</p>

## 5.5 Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:



### СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/44

Баруун-Урт сум

#### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Т.Цэрэгбаяр)-т хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Ө.Золзаяа)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоног, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор тус тус Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Т.Цэрэгбаяр) нарт хариуцуулсугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Ө.Золзаяа)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\А тушаал 2025.docx

2225010165